

## АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Аудитын гэрчилгээ	2
	Аудит хийгдсэн Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	4
	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
<b>Санхүүгийн аудитын газар</b>	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор:	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
	Товчилсон үгийн жагсаалт	8
Ц.Наранчимэг	Аудитын талаарх үндсэн мэдээлэл	10
Аудитын менежер:	Санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан аргачлал, зарчим	10
Г.Гүнжидмаа	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	13
	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	14
Ахлах аудитор:	Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14
	1.1 Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө	15
	1.2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	16
Ц.Хосжаргал	1.3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	16
	1.4 Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	17
Г.Жавхлан	Хоёр. Богино хугацаат хөрөнгө оруулалт	18
	2.1 Нийгмийн даатгалын сангийн богино хугацаат хөрөнгө оруулалт	18
Л.Хонгорзул	Гурав. Авлага, урьдчилгаа	18
	3.1. Авлага	18
Р.Цолмон	3.1.1 Төсөвт байгууллагын авлага	19
	3.1.2 Төрийн сангийн авлага	19
Аудитор:	3.1.3 Төсөл, сангийн авлага	20
Б.Сэржмядаг	3.1.4 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага	20
	3.1.5 Нийгмийн даатгалын сангийн авлага	20
П.Амарсанаа	3.2 Урьдчилгаа	20
	Дөрөв. Урт хугацаат хөрөнгө оруулалт	21
Ж.Болормаа	4.1 Төв төрийн сангийн урт хугацаат хөрөнгө оруулалт	21
	4.2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын урт хугацаат хөрөнгө оруулалт	22
Ц.Цэрэнхүү	Тав. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө	22
Г.Мөнхчимэг	5.1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал	22
	5.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал	22
Н.Золзаяа	5.3 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал	23
Б.Долгоржав	5.4 Бусад эргэлтийн хөрөнгө	23
	Зургаа. Үндсэн хөрөнгө	24
Д.Даваабаатар	6.1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө	24
	6.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө	25
Б.Баярмаа	6.3 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө	25
	Долоо. Өр төлбөр	25
Б.Ариунжаргал	7.1 Үнэт цаас, зээлийн өглөг	26
	7.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн зээлийн өглөг	27
	7.3 Дансны өглөг	28
	Найм. Засгийн газрын хувь оролцоо	29
	8.1 Төрийн өмчийн хувь оролцоо	29
	8.2 Орон нутгийн өмчийн хувь оролцоо	30
	Ес. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн	31
2018 оны 6 дугаар сар	9.1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	31
Уг тайланг УАГ-ын	9.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	31
Цахим хуудаснаас үзнэ үү: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	9.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	31
	9.4 Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	32
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаарын утсаар харилцана уу.	9.5 Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудит	33
	Арван. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга	33
	Арван нэг. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	34
	Арван хоёр. Дотоод аудит	34
	Арван гурав. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж	34
ХАЯГ:	Арван дөрөв. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	34
Үндэсний аудитын газар	Аудитын зөвлөмж	35
Засгийн газрын IV байр,	Аудитын тайланг баталгаажуулсан тушаал	36



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

2018.06.08 № 1315  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга нь мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Сангийн яам нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д. ХҮРЭЛБААТАР

## АУДИТ ХИЙГДСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,334,368,711.0	13,709,808,535.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,925,451,980.7	4,320,577,827.7
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	124,717,117.2	352,931,221.4
АВЛАГА	4,627,216,596.3	4,257,508,989.5
УРЬДЧИЛГАА	849,297,462.0	492,408,478.0
БАРАА МАТЕРИАЛ	1,055,566,620.8	1,684,037,526.4
НӨӨЦИЙН БАРАА	147,050,062.3	146,615,656.8
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,605,068,871.7	2,455,728,835.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,825,596,126.2	31,812,192,202.9
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	5,565,885,731.8	6,006,198,489.1
Урт хугацаат хадгаламж	1,170,781,806.5	1,109,767,108.5
Үнэт цаас	240,637,257.3	181,029,321.6
Урт хугацаат зээл	4,154,466,668.0	4,715,402,059.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,259,710,394.3	25,805,993,713.8
Газар	606,490.3	2,254,380.8
Биет хөрөнгө	12,397,940,470.6	13,678,167,422.9
Биет бус хөрөнгө	377,959,829.1	11,581,531,019.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	483,203,604.4	544,040,890.7
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>31,159,964,837.2</b>	<b>45,522,000,738.4</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,843,660,939.6	28,068,248,097.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,854,807,852.0	4,400,376,010.5
Богино хугацаат үнэт цаас	1,825,741,379.6	1,407,116,000.9
Богино хугацаат зээлийн өглөг	548,711,482.7	1,500,985,459.0
Өглөг	1,133,436,776.9	1,043,667,229.8
Урьдчилж орсон орлого	346,918,212.9	448,607,320.8
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,988,853,087.6	23,667,872,087.1
Урт хугацаат үнэт цаас	7,932,106,664.3	10,878,146,261.2
Урт хугацаат зээл	13,056,746,423.3	12,789,725,825.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,316,303,897.5	17,453,752,640.7
Засгийн газрын хувь оролцоо	6,316,303,897.5	17,453,752,640.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,155,062,099.7	4,027,615,169.1
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,860,724,535.4	3,067,962,563.7
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	175,110.7	20,369,854.6
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	38,355,868.4	11,234,355,868.4
Халаасны хувьцаа /ТӨҮГ/	0.0	0.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	33,784,215.5	37,572,403.6
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,352,268,265.7	2,523,572,833.3
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-5,032,738,590.4</b>	<b>-5,342,622,677.0</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,892,819,280.2	1,869,444,936.9
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	15,853,112.3	16,109,185.8
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	-627,497.7
Нөөцийн сан	0.0	0.0
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>31,159,964,837.2</b>	<b>45,522,000,738.4</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,103,227,047.9</b>	<b>12,856,044,729.7</b>
ТАТВАРЫН ОРЛОГО	5,039,314,534.3	7,048,846,835.9
Орлогын албан татвар	1,044,091,549.0	1,641,723,369.3
Хувь хүний орлогын албан татвар	568,272,475.9	695,355,048.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,821,546.9	-44,474,216.7
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	681,916.2	446,029.4
ААН-ын орлогын албан татвар	519,958,703.8	990,396,507.8
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,261,837,671.8	1,439,650,402.9
Хөрөнгийн албан татвар	104,662,923.9	131,129,627.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,140,721,391.8	1,618,492,105.6
Онцгой албан татвар	630,124,810.0	519,721,527.5
Тусгай зориулалтын орлого	10,767,441.6	12,386,570.0
Гадаад үйл ажиллагааны орлого	328,490,630.4	512,351,193.0
Бусад татвар, төлбөр, хураамж	518,618,115.8	1,173,392,040.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,669,318,700.1	5,674,156,979.6
Нийтлэг татварын бус орлого	4,447,058,099.5	5,487,473,750.8
Хөрөнгийн орлого	16,237,524.2	29,112,378.7
Тусламжийн орлого	204,598,584.9	146,872,687.3
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,424,491.5	946,062.4
Зээлийн орлого	0.0	9,752,100.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,593,813.5	133,040,914.2
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,598,820,694.5</b>	<b>10,904,829,712.5</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	10,029,513,180.3	10,430,123,538.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,658,579,494.3	5,904,527,907.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,978,991,327.7	2,053,127,522.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,226,818.3	192,406,898.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	240,710,454.6	261,286,831.4
Хангамж, бараа материалын зардал	523,531,329.0	486,077,491.8
Нормативт зардал	267,746,365.2	312,030,370.8
Эд хогшил, урсгал засварын зардал	73,982,824.2	62,186,299.0
Томилолт, зочны зардал	64,032,637.1	70,122,137.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,108,360,418.3	1,287,158,847.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,214,997,320.0	1,180,131,508.4
ХҮҮ	1,592,529,267.1	1,731,483,557.8
ТАТААС	301,990,417.4	201,531,610.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,476,414,001.6	2,592,580,462.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	569,307,514.2	474,706,173.7
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>-495,593,646.7</b>	<b>1,951,215,017.2</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	632,214,343.8	368,440,097.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,631,316,847.3	1,259,714,681.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>-3,494,696,150.2</b>	<b>1,059,940,432.4</b>

**АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,154,721,211.2	0.0	10,154,721,211.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,355,700,985.0	0.0	-1,355,700,985.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,799,020,226.2	0.0	8,799,020,226.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-80,758,341.7	0.0	-80,758,341.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,088,142,026.1	0.0	1,088,142,026.1
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	4,596,137.2	0.0	4,596,137.2
Тайлант үеийн үр дүн	-3,494,696,150.2	0.0	-3,494,696,150.2
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,316,303,897.5	0.0	6,316,303,897.5
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,316,303,897.5	0.0	6,316,303,897.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,438,202,030.8	0.0	-1,438,202,030.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,878,101,866.7	0.0	4,878,101,866.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-24,595,626.3	0.0	-24,595,626.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	251,286,215.9	0.0	251,286,215.9
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	87,645,074.5	0.0	87,645,074.5
Өмчид гарсан өөрчлөлт	11,202,135,202.4	0.0	11,202,135,202.4
Зарласан ногдол ашиг	-760,524.8	0.0	-760,524.8
Тайлант үеийн үр дүн	1,059,940,432.4	0.0	1,059,940,432.4
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,453,752,640.7	0.0	17,453,752,640.7

**АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>12,952,213,141.8</b>	<b>21,188,216,511.9</b>
ТАТВАРЫН ОРЛОГО	5,653,252,571.4	7,109,941,606.5
Орлогын албан татвар	1,670,461,373.5	1,641,444,434.6
Хувь хүний орлогын албан татвар	1,194,915,661.3	695,076,114.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,821,546.9	-44,474,216.7
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	681,916.2	446,029.4
ААН-ын орлогын албан татвар	519,685,342.9	990,396,507.8
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,240,678,858.1	1,432,240,077.8
Хөрөнгийн албан татвар	104,660,748.0	131,129,627.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,124,291,253.2	1,618,492,105.6
Онцгой албан татвар	630,124,810.0	519,721,527.5
Тусгай зориулалтын орлого	10,767,441.6	12,386,570.0
Гадаад үйл ажиллагааны орлого	328,490,630.4	512,351,193.0
Бусад татвар, төлбөр, хураамж	543,777,456.8	1,242,176,070.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	382,369,943.8	1,041,774,345.8
Газрын төлбөр	53,591,386.4	61,125,077.2
Байгалийн нөөц ашигласны төлбөр	53,189,623.2	68,428,084.3

Бусад татвар	54,626,503.2	70,848,563.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,223,667,706.0	13,215,279,421.6
Нийтлэг татварын бус орлого	6,129,645,496.3	13,134,794,995.7
Хөрөнгийн орлого	1,193,612.7	23,417,984.0
Тусламжийн орлого	91,404,105.5	56,136,889.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,424,491.5	929,552.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,075,292,864.4	862,995,483.8
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,548,036,264.5</b>	<b>18,002,879,612.1</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	13,548,036,264.5	18,002,879,612.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,670,313,987.6	13,532,143,559.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,295,089,090.1	2,423,941,997.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	268,171,997.6	294,335,986.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	342,247,310.9	318,205,227.1
Хангамж, бараа материалын зардал	1,189,333,545.1	1,453,567,206.5
Нормативт зардал	266,181,539.3	264,226,241.4
Эд хогшил, урсгал засварын зардал	61,414,902.8	65,315,204.1
Томилолт, зочны зардал	64,403,385.3	70,319,971.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,443,913,764.0	8,182,432,246.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,739,558,452.5	459,799,479.4
ХҮҮ	972,418,471.3	1,498,912,254.7
ТАТААС	224,801,413.8	246,915,741.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,680,502,391.8	2,724,908,055.9
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-595,823,122.7</b>	<b>3,185,336,899.8</b>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	485,812,365.6	103,940,345.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,165,695,899.8	1,855,921,054.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,165,695,899.8	1,855,921,054.3
Дотоод эх үүсвэрээр	2,165,695,899.8	1,855,198,002.8
Гадаад эх үүсвэрээр	0.0	723,051.5
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-1,679,883,534.2</b>	<b>-1,751,980,709.0</b>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,958,697,474.2	-785,002,669.0
Бусад эх үүсвэр	5,092,928,989.3	6,220,530,204.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	786,060,768.9	560,398,532.2
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	2,039,776,348.6	4,597,059,093.3
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>308,394,397.7</b>	<b>1,848,075,248.4</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-317,009,182.7</b>	<b>648,353,521.8</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,242,461,163.4	3,672,224,305.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,925,451,980.7	4,320,577,827.7

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖА	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДТС	Дулаан түгээх станц
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их сургууль
МУИС	Монгол Улсын Их сургууль
МСҮТ	Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУВС	Олон улсын валютын сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХК	Хувьцаат компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



## **АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, хугацаа**

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ**

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим юм.

Төрийн аудитын байгууллага Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргасан болно.

### **Аудитын арга зүй**

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

### **Материаллаг байдлын түвшин**

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,164.5 тэрбум төгрөгийн 2.0 хувь буюу 243.3 тэрбум төгрөгөөр тогтоолоо.

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХҮРЭЭ БА САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ**

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 дахь заалтын дагуу Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргаж, хуульд заасан хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д заасны дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллага хооронд үүссэн 33,782.8 тэрбум төгрөгийн орлого болон зардлын давхардсан ажил гүйлгээ, Төв төрийн сан болон төсвийн захирагчид хооронд үүссэн өглөг, авлагыг цэвэрлэж тайлагнасан;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 54 ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 4552 төсвийн байгууллага, төрийн сан, Засгийн газрын 22 тусгай сан, 547 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 90 төсөл хөтөлбөр, 955 хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан болон зардлын тайлан нийт 6166 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна” гэж заасны дагуу 90-ээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэжээ.

### Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл сууриар бэлтгэсэн байна.

### Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

### Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-ыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу “Э-тайлан” програмаар нэгтгэн гаргасан байна.

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд  1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

### Нягтлан бодох бүртгэлийн зарчим

### Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө гэдэгт бэлэн мөнгө болон хугацаагүй хадгаламж, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэл багатай, мөнгөний дүнд чөлөөтэй хувирдаг, түргэн хөрвөх чадвартай богино хугацаат хөрөнгө оруулалт юм.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдсэн байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансны Монголбанк дахь үлдэгдэл;
- Төрийн сангийн орлогын ерөнхий дансдын үлдэгдэл;
- Төсвийн байгууллага, сангуудын төрийн сангийн харилцах данс дахь үлдэгдэл;
- Төсвийн байгууллага, төсөл, сангийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Касст байгаа бэлэн мөнгө;
- Замд яваа мөнгөн хөрөнгө;
- Хадгаламж;
- 3 сар хүртэлх хугацаатай үнэт цаас

### **Богино хугацаат хөрөнгө оруулалт**

Богино хугацаат хөрөнгө оруулалтад Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын өрийн бичиг буюу богино хугацаат үнэт цаас хамаарна.

### **Авлага**

Авлага гэдэг нь үзүүлсэн ажил үйлчилгээ, нийлүүлсэн бүтээгдэхүүний төлөө худалдан авагчдаас нэхэмжилж буй мөнгөн дүн юм.

Зээлийн авлага нь бусдад зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийн төлөгдөөгүй байгаа үлдэгдэл дүнг илэрхийлнэ. Зээлийн авлагыг төлөгдөх дүнгээр нь хүлээн зөвшөөрсөн байна.

### **Урьдчилгаа**

Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнийг урьдчилан шилжүүлэх, ажлын хөлс, үйлчилгээний үнэд урьдчилан төлсөн урьдчилгаа болон урьдчилж төлсөн зардлуудыг хамруулна.

### **Бараа материал**

Бараа материалыг байнгын системийг ашиглаж бүртгэдэг ба төсвийн байгууллагууд бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тодорхойлно.

### **Урт хугацаат хөрөнгө оруулалт**

Төрийн өмчит хуулийн этгээд, олон улсын болон дотоодын банк, санхүүгийн байгууллагад оруулсан урт хугацаат хөрөнгө оруулалтуудыг хамруулсан байна.

### **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь болон Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төсвийн байгууллагын үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр хүлээн зөвшөөрсөн байна.

УСНББОУС17 “Үндсэн хөрөнгө”-ийн 54 дүгээр зүйл болон НББ-ийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөрөнгийг ашиглалтын хугацааны туршид нь системтэйгээр элэгдүүлж зардалд шингээнэ.

### **Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй боловч ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага юм.

## **Богино хугацаат өглөг**

Засгийн газрын богино хугацаат үнэт цаасны өр төлбөр, төсвийн байгууллага, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллагуудын нэг жилийн дотор барагдуулах ёстой өр төлбөрийг илэрхийлнэ.

## **Урт хугацаат өр төлбөр**

Урт хугацаат өр төлбөр гэдэг нь нэг жилээс дээш хугацаатай Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаасны төлбөр, гадаад хөнгөлөлттэй зээл, төсөл сан, төрийн өмчит хуулийн этгээдийн урт хугацаат зээл, хойшлогдсон өр төлбөрийг хамруулна.

## **Орлого хүлээн зөвшөөрөлт**

Улсын төсвийн орлогыг УСНББОУС болон нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл зарчмын дагуу орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

## **Зардал**

Нягтлан бодох бүртгэлийн аккруэл зарчмын дагуу зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

## **АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР**

### **Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эргэлтийн хөрөнгө 13,709.8 тэрбум, эргэлтийн бус хөрөнгө 31,812.2 тэрбум, нийт өр төлбөр 28,068.2 тэрбум, цэвэр хөрөнгө, өмчийн дүн 17,453.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт хөрөнгийн дүнд эргэлтийн хөрөнгө 30.1 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 69.9 хувийг эзэлж, өмнөх оноос 9.5 пунктээр эргэлтийн бус хөрөнгө нэмэгдсэн байна. Энэ нь биет бус хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эх үүсвэрийн дүнд нийт өр төлбөр 61.7 хувийг, цэвэр хөрөнгө, өмчийн дүн 38.3 хувийг эзэлж, өмнөх оноос цэвэр хөрөнгө, өмчийн дүн 18.1 пунктээр өссөн нь эздийн өмч нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### **Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 1,059.9 тэрбум төгрөгөөр илэрхийлэгджээ.

Өмнөх онтой харьцуулбал үйл ажиллагааны орлого 2,752.8 тэрбум төгрөгөөр, зардал 306.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд урсгал зардал өмнөх оноос 400.6 тэрбум төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний болон хүүгийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Улсын төсвийн орлогыг тохируулсан аккруэл зарчмын дагуу орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнажээ.

### **Нэгтгэсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан**

Засгийн газрын 2017 оны нэгтгэсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлангаар засгийн газрын хувь оролцоо 11,137.4 тэрбум төгрөгөөр өссөн нь эздийн өмч нэмэгдсэнтэй холбоотой байна.

## Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Засгийн газрын 2017 оны нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,395.1 тэрбум төгрөгөөр буюу 47.7 хувиар өссөн байна.

### Аудитын илрүүлэлт:

Төсвийн захирагчид санхүүгийн тайланд авлага, өглөгийг дутуу тайлагнаснаас Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 476.0 тэрбум төгрөгийн авлага, 57.6 тэрбум төгрөгийн өр төлбөрийн цэвэрлэх бичилт дутуу хийгдсэн.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

### Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2,925.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,320.6 тэрбум төгрөг болж, 1,395.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	71,380.4	55,936.9	-15,443.5	1.2
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,042,784.3	3,195,537.6	1,152,753.3	74.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	6,892.6	11,410.4	4,517.8	0.3
Хадгаламж	804,394.7	1,057,692.9	253,298.2	24.5
<b>Дүн</b>	<b>2,925,452.0</b>	<b>4,320,577.8</b>	<b>1,395,125.8</b>	<b>100.0</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	230,914.3	300,342.7	69,428.4	7.0
Төсөл сан	1,258,028.0	1,297,875.1	39,847.1	30.0
Төрийн сан	445,635.0	1,119,211.3	673,576.3	25.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	990,874.7	1,603,148.7	612,274.0	37.1
<b>Дүн</b>	<b>2,925,452.0</b>	<b>4,320,577.8</b>	<b>1,395,125.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 74.0 хувь нь харилцах дансад, 24.5 хувь нь хадгаламж хэлбэрээр, 1.2 хувь нь байгууллагуудын касст, 0.3 хувь нь замд яваа мөнгөн хөрөнгө байна.

Банкинд байршиж буй 3,195.5 тэрбум төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 918.2 тэрбум төгрөг байна.

Нийт 1,057.7 тэрбум төгрөгийн хадгаламжийн 52.2 хувь буюу 552.5 тэрбум төгрөг нь Монгол Улсын Хөгжлийн банкны, 42.6 хувь буюу 450.6 тэрбум төгрөг нь НДС-ийн, 3.3 хувь буюу 34.4 тэрбум төгрөг нь Төрийн банкны, 1.9 хувь буюу 20.2 тэрбум төгрөг нь их дээд сургуулиудын хадгаламж тус тус байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /төсвийн захирагчдаар/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Төв төрийн сан	295,733.0	929,950.9	634,217.9	21.5
Улсын ТЕЗ	1,463,712.4	1,947,922.9	484,210.5	45.1
Орон нутгийн ТЕЗ	292,721.2	345,026.0	52,304.8	8.0
Нийгмийн даатгалын сан	873,285.4	1,097,678.0	224,392.6	25.4
<b>Дүн</b>	<b>2,925,452.0</b>	<b>4,320,577.8</b>	<b>1,395,125.8</b>	<b>100.0</b>

## 1.1 Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 295.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 929.9 тэрбум төгрөг болж, 634.2 тэрбум төгрөгөөр өсөхөд улсын төсвийн валютын харилцах дансдын үлдэгдэл 222.3 тэрбум, төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл 427.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банкинд байгаа мөнгөн хөрөнгө</b>	<b>276,778.7</b>	<b>919,047.0</b>	<b>642,268.3</b>
Төгрөг	23,301.8	443,278.3	419,976.5
Төрийн сан	-	427,868.0	427,868.0
Монголбанк	7,250.6	7,858.8	608.2
Арилжааны банк	16,051.2	7,551.5	-8,499.7
Гадаад валют	253,476.9	475,768.7	222,291.8
Монголбанк	253,476.9	475,768.7	222,291.8
Замд яваа хөрөнгө	5,754.3	10,903.9	5,149.6
Хадгаламж	13,200.0	-	-13,200.0
<b>Нийт дүн</b>	<b>295,733.0</b>	<b>929,950.9</b>	<b>634,217.9</b>

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 48.8 хувийг төгрөгийн, 51.2 хувийг гадаад валютын харилцах дансдын үлдэгдэл эзэлж байна.

### Хүснэгт 4. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Валютын төрөл	Валютын үлдэгдэл /сая нэгж/	Монголбанкны 2017.12.30-ны хаалтын ханш	Эцсийн үлдэгдэл /сая төгрөг/
<b>Төрийн сангийн харилцах /төгрөгөөр/</b>				<b>427,868.0</b>
Улсын төсөв				414,276.6
Гаалийн түр горим				13,591.4
<b>Монголбанк дахь харилцах /төгрөгөөр/</b>				<b>7,858.8</b>
Хувийн хэвшлийг дэмжих 2 дахь төслийн эргэн төлөлт				2,543.7
Банкны үйлчилгээний шимтгэл				1.9
Эрдэнэс таван толгойн хувьцаа				2,748.9
Монголын ипотекийн зах зээлийн хөгжлийг дэмжих төсөл				2,563.8
Хүний хөгжил сан				0.6
<b>Монголбанк дахь харилцах /валютаар /</b>				<b>475,768.7</b>
Улсын төсөв /доллар/	USD	185.7	2,427.13	450,725.6
Улсын төсөв /евро/	EUR	0.5	2,897.87	1,474.7
Улсын төсөв /иен/	JPY	271.5	21.53	5,846.4
Дамжуулан зээл /доллар/	USD	0.2	2,427.13	449.6
Хувийн хэвшлийг дэмжих 2 дахь төслийн эргэлтийн сан	USD	0.8	2,427.13	1,944.4
Сангийн яам /юань/	CNY	41.3	371.58	15,328.0
<b>Арилжааны банк дахь харилцах /төгрөгөөр/</b>				<b>7,551.5</b>
Улаанбаатар банк /тусламж/				649.9
Капитал банк /тусламж/				7.5
Төрийн банк /"Эрдэнэс Тавантолгой"				6,894.1
ХК-ийн хувьцааны буцаалт/				
<b>Замд яваа хөрөнгө</b>				<b>10,903.9</b>
Татварын ерөнхий газар				7,086.2
Гаалийн ерөнхий газар				3,817.7
<b>Нийт дүн</b>				<b>929,950.9</b>

Эх сурвалж: Төв төрийн сан

Төрийн банк дахь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа худалдаж авсан иргэд, ААНБ-ын хувьцааны төлбөрийг буцаан олгох ажлыг зохицуулах гэрээний дагуу байршуулсан харилцах дансны үлдэгдэлд 0.3 тэрбум төгрөгийн хүүгийн орлого хуримтлагджээ.

**Аудитын илрүүлэлт:**

Засгийн газрын 2016 оны 334 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааг иргэдээс худалдан авах мөнгөн хөрөнгийг байршуулах данс нээсэн бөгөөд 2016 оны 33 дугаар тогтоолоор хувьцаа худалдан авах үйл ажиллагааг зогсоосон боловч 2.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй харилцах дансыг хаах талаар шийдвэр гаргаагүй байна.

**1.2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,947.9 тэрбум төгрөг нь нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 45.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт					/сая төгрөг/
	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	ТӨҮГ	Нийт	
Касст байгаа бэлэн мөнгө	1,262.5	8.0	54,131.8	55,402.3	
Банкинд байгаа бэлэн мөнгө	217,906.3	185,686.3	881,679.5	1,285,272.1	
Замд яваа мөнгөн хөрөнгө	86.0	-	79.6	165.6	
Хадгаламж	-	-	607,082.9	607,082.9	
<b>Дүн</b>	<b>219,254.8</b>	<b>185,694.3</b>	<b>1,542,973.8</b>	<b>1,947,922.9</b>	

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Аудитын илрүүлэлт:**

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн барьцаа хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 0.4 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 31.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал: БСШУСЯ 30.5 тэрбум төгрөгийн дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй, ХЗДХЯ 0.1 тэрбум төгрөгийн дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүй, мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан, Улсын дээд шүүх 0.1 тэрбум төгрөгөөр мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн, ХХААХҮЯ 0.1 тэрбум төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн;
- Жижиг мөнгөн сангийн журмаар тогтоосон хэмжээнээс давсан нийт 0.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй 13 төсвийн байгууллага байна.

**1.3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 345.0 тэрбум төгрөг нь нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 8.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт					/сая төгрөг/
	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	Төрийн сан	ОНӨҮГ	Нийт
Касст байгаа бэлэн мөнгө	89.3	2.7	0.1	442.4	534.5
Банкинд байгаа бэлэн мөнгө	80,639.1	14,859.6	188,919.4	59,712.5	344,130.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	340.9	-	340.9
Хадгаламж	-	-	-	20.0	20.0
<b>Дүн</b>	<b>80,728.4</b>	<b>14,862.3</b>	<b>189,260.4</b>	<b>60,174.9</b>	<b>345,026.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Аудитын илрүүлэлт:**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн, мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн, дансны үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зэрэг нийт 2.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал: Ховд аймгийн ТЕЗ 1.2 тэрбум, Нийслэлийн ТЕЗ 0.9 тэрбум, Хэнтий аймгийн ТЕЗ 0.1 тэрбум, Орхон аймгийн ТЕЗ 0.1 тэрбум төгрөг.

#### 1.4 Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 25.4 хувь буюу 1,097.7 тэрбум төгрөгийг НДС-ийн мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 7. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	1.0	-	-1.0	
Харилцах данс	290,164.8	647,088.0	356,923.2	59.0
Замд яваа мөнгө	119.6	-	-119.6	
Хадгаламж	583,000.0	450,590.0	-132,410.0	41.0
<b>Дүн</b>	<b>873,285.4</b>	<b>1,097,678.0</b>	<b>224,392.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Харилцах дансдын мөнгөн хөрөнгөөс тайлант онд 12.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

НДС-ийн чөлөөт үлдэгдлээс хадгаламжийн дансдад байршиж буй мөнгөн хөрөнгийн хэмжээ 450.6 тэрбум төгрөг болж өмнөх оноос 132.4 тэрбум төгрөгөөр буурсан нь оны эцэст 226.4 тэрбум төгрөгийн хадгаламжийн хугацаа дууссанаас шалтгаалжээ.

НДС-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс 2015 онд 467.0 тэрбум, 2016 онд 583.0 тэрбум, 2017 онд 450.6 тэрбум төгрөгийг арилжааны 9 банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсан байна. Тайлант онд хадгаламжийн хүүгээс 89.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Хүснэгт 8. Арилжааны банкуудад байршуулсан хадгаламж

Банкны нэр	ҮОМШӨ-ий даатгалын сан	Эрүүл мэндийн даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	/сая төгрөг/ Дүн
Улаанбаатар хотын банк	51,156.0	61,055.0	46,789.0	159,000.0
Голомт банк	10,000.0	30,000.0	-	40,000.0
Капитал банк	8,000.0	10,000.0	2,000.0	20,000.0
Капитрон банк	11,000.0	-	4,000.0	15,000.0
Төрийн банк	5,000.0	20,000.0	-	25,000.0
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2,500.0	17,500.0	5,000.0	25,000.0
Хаан банк	18,000.0	-	-	18,000.0
Худалдаа хөгжлийн банк	55,000.0	16,000.0	-	71,000.0
Чингис хаан банк	62,120.0	12,500.0	2,970.0	77,590.0
<b>Дүн</b>	<b>222,776.0</b>	<b>167,055.0</b>	<b>60,759.0</b>	<b>450,590.0</b>

Хүснэгт 9. Хадгаламжийн хүүгийн өөрчлөлт

Огноо	Хүүгийн хэмжээ		
	Монголбанкны бодлогын хүү	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор	Хүүгийн хэмжээ
2016.01.14	12.0	Огноо/Тогтоолын дугаар	2016.01.18 №61
2016.05.05	10.5		2016.05.17 №15
2016.08.18	15.0		2016.12.15 №33
2016.12.19	14.0		

Хадгаламжийн хүүг НДҮЗ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолоор 15.0 хувь болгосон ба тайлант онд хүүгийн хэмжээ өөрчлөгдөөгүй байна.

#### Хоёр. Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 124.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 352.9 тэрбум төгрөг болж 228.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэлд Төрийн банк дахь



343.3 тэрбум, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2.5 тэрбум төгрөгийн үнэт цаас, Боловсролын зээлийн сангийн 7.1 тэрбум төгрөгийн банкуудад олгосон санхүүжилт байна.

## 2.1 Нийгмийн даатгалын сангийн богино хугацаат хөрөнгө оруулалт

НДС-ийн богино хугацаат хөрөнгө оруулалтын дансны эцсийн үлдэгдэл 57.0 тэрбум төгрөг байгаа ба тайлант онд үнэт цаасны нөхцөл /хүү, хугацаа/ өөрчлөгджээ. Бондын хүүгийн орлогод 6.8 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Хүснэгт 10. Бонд

Сангийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Эрүүл мэндийн даатгалын сан	33,200.0	33,200.0	58.2
ҮОМШӨ сан	16,900.0	16,900.0	29.7
Ажилгүйдлийн сан	6,900.0	6,900.0	12.1
<b>Дүн</b>	<b>57,000.0</b>	<b>57,000.0</b>	<b>100.0</b>

## Гурав. Авлага, урьдчилгаа

### 3.1 Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага

Авлагын эхний үлдэгдэл 4,627.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,257.5 тэрбум төгрөг болж 369.7 тэрбум төгрөгөөр буурсан нь Ирээдүйн өв сангаас авах 196.8 тэрбум төгрөгийн авлага барагдсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Нийт авлага байгууллагын төрлөөр, төсвийн захирагчдаар

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	711,494.7	1,023,051.9	311,557.2	24.0
Төрийн сан	2,428,355.5	1,255,593.0	-1,172,762.5	29.5
Төсөл сан	498,396.4	263,195.9	-235,200.5	6.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	988,969.9	1,715,668.2	726,698.3	40.3
<b>Дүн</b>	<b>4,627,216.5</b>	<b>4,257,509.0</b>	<b>-369,707.5</b>	<b>100.0</b>
<i>Үүнээс, төсвийн захирагчдаар</i>				
Улсын ТЕЗ	1,862,707.2	2,652,528.3	789,821.1	62.3
Төрийн сан	2,422,723.1	1,250,801.6	-1,171,921.5	29.4
Нийгмийн даатгалын сан	114,755.3	123,687.7	8,932.4	2.9
ОНТЕЗ	227,030.9	230,491.4	3,460.5	5.4

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.1.1 Төсвийн байгууллагын авлага

Төсвийн байгууллагын авлага 1,023.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 311.6 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 24.0 хувийг эзэлж байна.

Тайлант онд БСШУСЯ, УУХҮЯ, СЯ-ны авлага 10.0-15.0 тэрбум төгрөгөөр, Нийслэлийн ТЕЗ, Орхон аймгийн ТЕЗ, Төв аймгийн ТЕЗ-дын авлага 1.0-4.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь Боловсролын зээлийн сан, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, “Хөдөөгийн хөгжил” төсөл, Монгол Улсын Хөгжлийн банк, Нийслэлийн тээврийн газар, “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн дансны авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

- БСШУСЯ 12.0 тэрбум, ЗТХЯ 1.1 тэрбум, Нийслэлийн ТЕЗ 1.1 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Хөвсгөл аймгийн ТЕЗ 1.7 тэрбум, Булган аймгийн ТЕЗ 1.7 тэрбум, Дундговь аймгийн ТЕЗ 0.9 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй;
- Тайлант онд ЭХЯ 1.7 тэрбум, Нийслэлийн ТЕЗ 0.6 тэрбум, ХЗДХЯ 0.1 тэрбум төгрөгөөр авлагыг нэмэгдүүлсэн байна.

### 3.1.2 Төрийн сангийн авлага

Төрийн сангийн авлагын эхний үлдэгдэл 2,428.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,255.6 тэрбум төгрөг болж 1,172.8 тэрбум төгрөгөөр буурсан ба нийт авлагын 29.5 хувийг эзэлж байна.

Төв төрийн сангийн нийт авлагын 55.0 хувийг гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага, 45.0 хувийг бусад авлага эзэлж байна.

Он удаан жил болсон “Анод”, “Зоос”, “ХОТШ”, “Ард” банкуудын эрх хүлээн авагчаас авах 80.5 тэрбум, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах 29.5 тэрбум, татан буугдсан 26 хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой 20.6 тэрбум төгрөгийн зэрэг авлага бүртгэлтэй байна.

#### Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эхний үлдэгдэл 1,777.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,908.5 тэрбум төгрөг болж 131.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд нийт 151.2 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт гарч, 30.9 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн төлбөр, 13.8 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн орлого нийт 44.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ. Төвлөрүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 11.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дээрх дамжуулан зээл нь 15 донор байгууллагаас 9 төрлийн валютаар олгосон зээл бөгөөд тайлант онд 10.8 тэрбум төгрөгийн валютын ханшийн зөрүүний алдагдал хүлээжээ.

Дамжуулан зээлийн авлагын 45.4 хувь буюу 866.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй олон жил болсон ба валютын ханшийн өөрчлөлтөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- 1991-1996 онд олгосон зээл 274.3 тэрбум төгрөг;
- ЗТХЯ-ны тайланд тусгагдаагүй 106.4 тэрбум төгрөг;
- Шүүхийн шийдвэрээр бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 2.1 тэрбум төгрөг;
- Эрчим хүчний хөгжлийн төвийн санхүүгийн тайланд тусгагдаагүй 90.5 тэрбум төгрөг;
- Анод банкинд олгосон 2.6 тэрбум төгрөг;
- Төрийн холбооны газрын 15.8 тэрбум төгрөг;
- Засгийн газрын холбогдох тогтоолтой 101.3 тэрбум төгрөг;
- Төрийн албан хаагчдад олгосон байрны төлбөр 0.2 тэрбум төгрөг;
- Орон нутгийн байгууллагын өөрийн орлогоос шалтгаалан эргэн төлөлт хийгдээгүй 273.6 тэрбум төгрөг тус тус байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Аж ахуйн нэгж, байгууллагуудад 1991-1996 онд олгосон 274.3 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн найдваргүй болох эрсдэлтэй зээлийн авлага байна;
- Зээл ашиглагч байгууллагын дүрмийн санг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтад тооцох тухай Засгийн газрын тогтоолуудтай 101.3 тэрбум, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 2.1 тэрбум, нийт 103.4 тэрбум төгрөгийн авлагыг шийдвэрлэх талаар холбогдох байгууллагууд арга хэмжээ аваагүй байна.

### 3.1.3 Төсөл сангийн авлага

Төсөл сангийн авлага 263.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 235.2 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд нийт авлагын 6.2 хувийг эзэлж байна.

Төсөл сангийн нийт авлагын үлдэгдэлд Нийслэлийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн авлага 85.1 тэрбум, ХХААХҮЯ-ны харьяа “Бага оврын трактор худалдан авах төсөл”-ийн нэгжийн авлага 51.7 тэрбум, КР-1 төслийн 31.8 тэрбум төгрөгийн авлага тайлагнасан байна.

### 3.1.4 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага 1,715.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 726.7 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 40.3 хувийг эзэлж байна.

Нийт авлагын үлдэгдэлд Монгол Улсын Хөгжлийн банкны 1,120.1 тэрбум, “ТОСК” ТӨҮГ-ын 134.5 тэрбум, “Хадгаламж даатгалын корпораци” ХК-ийн 87.1 тэрбум, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 43.1 тэрбум төгрөгийн авлага байна.

**Аудитын илрүүлэлт:**

- МУИС, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Дулаан шарын гол” ТӨХК, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ, “Чингис хаан олон улсын нисэх буудал” ТӨҮГ зэрэг байгууллагууд нийт 1.5 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- “Харгуй” ТӨҮГ, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ зэрэг байгууллагуудын нийт 1.0 тэрбум төгрөгийн авлага он удаан жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй байна.

### 3.1.5 Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн авлагын эхний үлдэгдэл 114.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 123.7 тэрбум төгрөг болж, 8.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 12. Нийгмийн даатгалын сангийн авлага

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өсөлт /+/, бууралт -/	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	104,107.2	110,174.6	6,067.4	89.1
Татаас, санхүүжилтийн авлага	1,795.5	4,388.4	2,592.9	3.5
Зээлийн хүүгийн авлага	295.9	-	-295.9	0.0
Байгууллагаас авах авлага	8,495.7	9,052.0	556.2	7.3
Хувь хүмүүсээс авах авлага	60.9	72.7	11.8	0.1
<b>Дүн</b>	<b>114,755.3</b>	<b>123,687.7</b>	<b>8,932.4</b>	<b>100.0</b>

Тайлант оны авлагын өсөлтөд төлбөртэй үйлчилгээний авлага 6.0 тэрбум, татаас санхүүжилтийн авлага 2.5 тэрбум, байгууллагаас авах авлага 0.5 сая төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн нь нөлөөлжээ.

### 3.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 849.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 492.4 тэрбум төгрөг болж 356.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 13. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, Бууралт -/	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	304,930.3	283,696.8	-21,233.5	57.6
Төрийн сан	64,995.2	64,995.2	0.0	13.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	451,149.7	127,762.5	-323,387.2	25.9
Төсөл, сангууд	28,222.3	15,954.0	-12,268.3	3.3
<b>Дүн</b>	<b>849,297.5</b>	<b>492,408.5</b>	<b>-356,889.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлд ЗТХЯ 41.1 хувь буюу 202.5 тэрбум, УУХҮЯ 14.3 хувь буюу 70.5 тэрбум, ЭХЯ 14.8 хувь буюу 72.8 тэрбум, ЭМЯ 4.0 хувь буюу 19.8 тэрбум, бусад яамд болон аймгийн ТЕЗ-д 25.8 хувь буюу 126.8 тэрбум төгрөгийг тус тус эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 2 хэлхээтэй 220 КВт-ын Цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 КВт-ын дэд станцын барилга угсралтын 213.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийг 2013 онд улсын комисс хүлээн авсан боловч ЭХЯ-ны санхүүгийн тайланд тусгаагүй зөрчлийг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

## Дөрөв. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 5,565.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 6,006.2 тэрбум төгрөг болж 440.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 14. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/-, Бууралт -/-	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	1,170,781.8	1,109,767.1	-61,014.7	18.5
Үнэт цаас	240,637.2	181,029.3	-59,607.9	3.0
Урт хугацаат зээл	4,154,466.7	4,715,402.1	560,935.4	78.5
<b>Дүн</b>	<b>5,565,885.7</b>	<b>6,006,198.5</b>	<b>440,312.8</b>	<b>100.0</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	5,035.0	30,676.4	25,641.4	0.5
Төрийн сан	1,270,911.7	1,591,178.8	320,267.1	26.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,289,939.0	4,384,343.3	94,404.3	73.0
<b>Дүн</b>	<b>5,565,885.7</b>	<b>6,006,198.5</b>	<b>440,312.8</b>	<b>100.0</b>

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 6,006.2 тэрбум төгрөгийн үлдэгдлээс СЯ 47.4 хувийг, УУХҮЯ 25.9 хувийг, Төв төрийн сан 26.5 хувийг, бусад ТЕЗ-д 0.2 хувийг тус тус эзэлж байна.

### 4.1 Төв төрийн сангийн урт хугацаат хөрөнгө оруулалт

Төв төрийн сангийн урт хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оноос 320.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал:

- ОУВС-д оруулсан 205.9 тэрбум төгрөгийн хувь оролцоо валютын ханшийн өөрчлөлтөөр 36.6 тэрбум төгрөгөөр,
- ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн дагуу тайлант онд 83.9 сая нэгж зээлжих тусгай эрхийг санхүүгийн жилийн ханш /ОУВС/-аар хөрвүүлж 278.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төв төрийн сангийн үлдэгдэлд ихээхэн хувь эзэлж байгаа дараах урт хугацаат хөрөнгө оруулалтууд байна. Тухайлбал:

- Сангийн сайдын 2016 оны 440 дүгээр тушаалаар Монгол Улсын Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн 1,000.0 тэрбум төгрөг;
- Төрийн банкинд оруулсан 28.0 тэрбум төгрөгийн хувь оролцоог тус тус бүртгэсэн байна.

### 4.2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын урт хугацаат хөрөнгө оруулалт

Улсын ТЕЗ-дын урт хугацаат хөрөнгө оруулалтын 4,415.0 тэрбум төгрөгийн үлдэгдлээс СЯ 64.4 хувийг, УУХҮЯ 35.2 хувийг, бусад ТЕЗ-д 0.4 хувийг тус тус эзэлж байна.

“Мон-Чех ураниум” ХХК-ийн дүрэмд заасны дагуу “Мон Атом” ХХК-иас оруулсан 51.0 хувьтай тэнцэх 51.0 мянган ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

## Тав. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө

Бараа материалын эхний үлдэгдэл 1,055.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,684.0 тэрбум төгрөг болж 628.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 15. Бараа материал

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/-, Бууралт -/-	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	108,475.0	120,538.8	12,063.8	7.2
Эм боох материал	31,643.7	28,808.0	-2,835.7	1.7

Дуусаагүй үйлдвэрлэл	192,972.2	575,612.0	382,639.8	34.2
Бэлэн бүтээгдэхүүн	128,527.5	291,699.3	163,171.8	17.3
Бичиг хэргийн материал	13,562.3	15,007.5	1,445.2	0.9
Аж ахуйн материал	124,445.7	131,098.1	6,652.4	7.8
Сэлбэг хэрэгсэл	90,885.6	100,835.8	9,950.2	6.0
Түлш шатахуун, тослох материал	25,736.3	26,440.8	704.5	1.6
Барилга засварын материал	15,135.9	46,113.4	30,977.5	2.7
Хүнсний материал	16,798.0	15,478.5	-1,319.5	0.9
Бусад хангамжийн материал	283,016.9	303,871.4	20,854.5	18.0
Биологийн хөрөнгө	24.5	29.1	4.6	0.0
Мал амьтад	24,343.0	28,504.8	4,161.8	1.7
<b>ДҮН</b>	<b>1,055,566.6</b>	<b>1,684,037.5</b>	<b>628,470.9</b>	<b>100.0</b>
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	701,280.0	794,659.0	93,379.0	47.2
Төсөл, сан	10,673.1	4,424.6	-6,248.5	0.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	343,613.5	884,953.9	541,340.4	52.5
<b>ДҮН</b>	<b>1,055,566.6</b>	<b>1,684,037.5</b>	<b>628,470.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд “Эрдэнэс Тавантолгой” ХК 417.6 тэрбум, “Монголын төмөр зам” ТӨХК 112.0 тэрбум, СЯ-нд хэрэгжиж буй “Хөгжлийн хөтөч” төслийн бараа материал 64.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь өсөлтөд нөлөөлжээ.

### 5.1. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 867.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,491.6 тэрбум төгрөг болж 623.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын ТЕЗ-дын нийт бараа материалын 38.0 хувийг дуусаагүй үйлдвэрлэл, 19.4 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 16.6 хувийг бусад хангамжийн материал, 26.0 хувийг бусад бараа материал эзэлж байна.

### 5.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 187.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 192.5 тэрбум төгрөг болж 4.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт бараа материалын 38.7 хувийг аж ахуйн, 29.4 хувийг бусад хангамжийн, 9.9 хувийг тусгай зориулалтын, 22.0 хувийг бусад бараа материал тус тус эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Хэнтий аймгийн ТЕЗ 0.2 тэрбум, Дорнод аймгийн ТЕЗ 0.1 тэрбум, Баян-Өлгий аймгийн ТЕЗ 70.0 сая, Дундговь аймгийн ТЕЗ 40.0 сая төгрөгийн бараа материалыг дансны ангилал буруу бүртгэсэн;
- Баян-Өлгий аймгийн ТЕЗ 0.1 тэрбум төгрөгийн бараа материалыг зардалд шууд тусгасан;
- Дундговь аймгийн ТЕЗ 70.0 сая төгрөгийн бараа материалын анхан шатны баримтын бүрдэл дутуу, 0.3 тэрбум төгрөгийн бараа материалын тооллого, тооцоог хийгээгүй байна.

### 5.3 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 343.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 884.9 тэрбум төгрөг болж 541.3 тэрбум төгрөгөөр өссөн нь ЗТХЯ 422.2 тэрбум, УУХҮЯ 111.6 тэрбум, бусад ТЕЗ 4.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн бараа материалын үлдэгдэл 833.8 тэрбум төгрөгөөс ЗТХЯ 498.1 тэрбум төгрөг буюу 59.7 хувийг, УУХҮЯ 193.2 тэрбум төгрөг буюу 23.2 хувийг, БХБЯ 61.0 тэрбум төгрөг буюу 7.3 хувийг, бусад ТЕЗ 81.5 тэрбум төгрөг буюу 9.8 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал 3.2 тэрбум төгрөгөөр өссөн нь Нийслэлийн ТЭЗ 2.4 тэрбум, Сэлэнгэ аймгийн ТЭЗ 0.3 тэрбум, Дундговь аймгийн ТЭЗ 0.3 тэрбум, бусад аймгийн ТЭЗ 0.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

- “Бөртэ” ТӨААТҮГ 1.3 тэрбум төгрөгийн бараа материалыг сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдан авсан;
- “Шивээ овоо” ХК-ийн нийт бараа материалын 56.4 хувь буюу 7.2 тэрбум төгрөгийн хэрэгцээ, шаардлага хангахгүй бараа материалын үлдэлдэлтэй байна.

### 5.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,605.1 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,455.7 тэрбум төгрөг болж, 149.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 16. Бусад эргэлтийн хөрөнгө

Хөрөнгийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Бусад санхүүгийн хөрөнгө	64,513.1	281,993.7	217,480.6	11.5
Бусад эргэлтийн хөрөнгө	2,173,148.3	1,938,046.9	-235,101.4	78.9
Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	367,407.5	235,688.2	-131,719.3	9.6
<b>Дүн</b>	<b>2,605,068.9</b>	<b>2,455,728.8</b>	<b>-149,340.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн 88.4 хувийг улсын ТЭЗ, 11.6 хувийг орон нутгийн ТЭЗ-дын хөрөнгө эзэлж байгаа бөгөөд тайлант онд 149.4 тэрбум төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийг эзэмшигч байгууллагуудад шилжүүлснээс шалтгаалжээ.

**Аудитын илрүүлэлт:**

ЗТХЯ хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр бэлтгэсэн 57.0 тэрбум төгрөгийн 65 ширхэг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг сайжруулах тоног төхөөрөмж ашиглагдахгүй, эргэлтийн хөрөнгийн бусад хэсэгт бүртгэлтэй байна.

### Зургаа. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө цэвэр дүнгээр эхний үлдэгдэл 13,259.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 25,806.0 тэрбум төгрөг болж 12,546.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн 53.0 хувийг биет хөрөнгө, 44.8 хувийг биет бус хөрөнгө, 2.2 хувийг газар болон бусад хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 17. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, Бууралт/-	Дүнд эзлэх хувь
Газар	606.5	2,254.4	1,647.9	0.1
Биет хөрөнгө	12,397,940.5	13,678,167.4	1,280,226.9	10.2
Биет бус хөрөнгө	377,959.8	11,581,531.0	11,203,571.2	89.3
Бусад хөрөнгө ТӨҮГ	483,203.6	544,040.9	60,837.3	0.4
<b>Дүн</b>	<b>13,259,710.4</b>	<b>25,805,993.7</b>	<b>12,546,283.3</b>	<b>100.0</b>
<i>Үүнээс байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	8,644,251.6	9,975,162.7	1,330,911.1	10.6
Төсөл сан	215,401.4	40,214.3	-175,187.1	-1.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,400,057.4	15,790,616.7	11,390,559.3	90.8

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 6.1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 21,750.6 тэрбум төгрөг болж нийт хөрөнгийн 84.3 хувийг эзэлж байна.

Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолын 8 дугаар зүйлийн 8.2-т “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үндэслэн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, нийт гаргасан хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд тусгах” гэж заасны дагуу 12.0 тэрбум ширхэг хувьцааг 11,196.0 тэрбум төгрөгөөр санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгэсэн нь өсөлтөд нөлөөлжээ.

“Эрдэнэс Тавантолгой” ХК ордын нөөцийн бодит үнэлгээг гаргаж баталгаажуулаагүй, Засгийн газрын тогтоолыг үндэслэн хөрөнгө дансанд бүртгэсэн нь тайлант хугацааны эцсийн өдрөөрх дансны үлдэгдлийн талаарх иж бүрэн байдал, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Мөн БСШУСЯ-ны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө 120.9 тэрбум, ЗТХЯ-ны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө 430.4 тэрбум, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн хөрөнгө 177.2 тэрбум, ЭХЯ-ны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө 176.7 тэрбум төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгджээ.

**Аудитын илрүүлэлт:**

- БСШУСЯ: Тайлант онд ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр 9.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг данснаас хассан;
- ГХЯ: “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй 5.3 тэрбум төгрөгийн “Дипломат 95 цогцолбор” орон сууцыг Засгийн газрын 2016 оны 315 дугаар тогтоолоор албан хаагчдад үнэ төлбөргүй хувьчлах тухай шийдвэрийг хууль, тогтоомжид нийцүүлэх талаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй;
- ЗТХЯ: ИНЕГ-ын санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй гэрээний хугацаа дууссан боловч ажил нь дуусаагүй 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээ байна;
- Ерөнхий сайд: “Үндэсний Дата төв” УТҮГ нь тайлант онд урсгал зардлаас 0.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- УУХҮЯ: ТӨБЗГ-ын 2016 оны 125 дугаар тогтоолоор 0.5 тэрбум төгрөгийн барилга, байгууламж УУХҮЯ-д шилжиж ирсэн боловч эзэмших эрхийн гэрчилгээ нь ХХААХҮЯ-ны нэр дээр бүртгэлтэй;
- Шүүхийн ерөнхий зөвлөл: Тайлант онд 0.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэргүйгээр бэлтгэсэн;
- ХНХЯ: Дорнод аймгийн Хэрлэн сумын МСҮТ-ийн хичээлийн байр, Орхон аймгийн МСҮТ-ийн дотуур байр барьж ашиглалтад оруулах ажлын гэрээнүүд 2014 онд 6 сарын хугацаатай хийгдсэн боловч гэрээний хугацаа 2-3 жилээр сунгагдаж, төсөвт өртөг 1.1-1.2 тэрбум төгрөгөөр өссөн;
- ЭХЯ-ны харьяа байгууллагууд сонгон шалгаруулалтгүйгээр 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг шууд гэрээ байгуулж, худалдан авсан;
- ЭМЯ: Монгол-Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 0.1 тэрбум төгрөгийн өртөгтэй өргөтгөлийн барилгыг “Оргил рашаан сувилал” ТӨХК-ийн эзэмшлийн газар дээр 2001 онд барьж, ашиглалтад оруулсан боловч газрын зөвшөөрөлгүйгээс өөрийн эзэмшилд аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

## 6.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө

Орон нутгийн ТЕЗ-дын үндсэн хөрөнгө 352.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 4,055.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж, нийт үндсэн хөрөнгийн 15.7 хувийг эзэлж байна. Тухайлбал: Тайлант онд Нийслэлийн ТЕЗ-ийн барилга, нийтийн эзэмшлийн хөрөнгө 121.5 тэрбум, бусад хөрөнгө 51.4 тэрбум төгрөгөөр, Өмнөговь аймгийн ТЕЗ-ийн барилга, байгууламж 18.9 тэрбум, бусад хөрөнгө 22.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд тооллого хийж, тооцоог бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, данс бүртгэлээс хассан, урсгал зардлаас хөрөнгө худалдан авсан, дансны ангиллыг буруу бүртгэсэн, орлогод тусгаагүй зэрэг зөрчил илэрлээ. Тухайлбал: Ховд аймгийн ТЕЗ 21.0 тэрбум, Нийслэлийн ТЕЗ 11.5 тэрбум, Өвөрхангай аймгийн ТЕЗ 1.0 тэрбум, Орхон аймгийн ТЕЗ 0.8 тэрбум, Хэнтий аймгийн ТЕЗ 0.8 тэрбум, Сүхбаатар аймгийн ТЕЗ 0.3 тэрбум, Баян-Өлгий аймгийн ТЕЗ 0.1 тэрбум, Булган аймгийн ТЕЗ 0.1 тэрбум, Говьсүмбэр аймгийн ТЕЗ 0.1 тэрбум төгрөг тус тус байна.

### 6.3 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 15,790.6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн 62.2 хувийг эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн хөрөнгийн дансанд “Цагаан хад дахь гаалийн талбай”-д байршилтай, 5.3 тэрбум төгрөгийн өртөгтэй ашиглалтгүй хөрөнгө байна;
- “Эрдэнэс Монгол” ХХК Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 157.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 239 км авто замыг данс бүртгэлд тусгасан боловч өмчлөх эрхгүй гэсэн шалтгаанаар элэгдэл тооцоогүй;
- СУИС шийдвэргүйгээр 0.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан;
- МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар сургууль 2.1 тэрбум төгрөгийн оюутны дотуур байрны барилгыг үндсэн хөрөнгөнд бүртгээгүй;
- “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК шийдвэргүйгээр 0.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

### Долоо. Өр төлбөр

Нийт өр төлбөр оны эхэнд 24,843.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 28,068.2 тэрбум төгрөг болж, 3,224.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 18. Нийт өр, төлбөрийн дансны ангилал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/-, Бууралт -/-	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	3,854,807.9	4,400,376.0	545,568.1	15.7
Богино хугацаат үнэт цаас	1,825,741.4	1,407,116.0	-418,625.4	5.0
Богино хугацаат зээлийн өглөг	548,711.5	1,500,985.5	952,274.0	5.3
Өглөг	1,133,436.8	1,043,667.2	-89,769.6	3.7
Урьдчилж орсон орлого	346,918.2	448,607.3	101,689.1	1.6
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	20,988,853.1	23,667,872.1	2,679,019.0	84.3
Урт хугацаат үнэт цаас	7,932,106.7	10,878,146.3	2,946,039.6	38.8
Урт хугацаат зээл	13,056,746.4	12,789,725.8	-267,020.6	45.6
<b>Нийт дүн</b>	<b>24,843,661.0</b>	<b>28,068,248.1</b>	<b>3,224,587.1</b>	<b>100.0</b>
<i>Үүнээс байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	252,298.3	259,109.5	6,811.2	0.9
Төсөл сан	103,505.0	71,620.3	-31,884.7	0.3
Төрийн сан	16,907,962.1	20,916,674.3	4,008,712.2	74.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	7,579,895.6	6,820,844.0	-759,051.6	24.3
<b>Дүн</b>	<b>24,843,661.0</b>	<b>28,068,248.1</b>	<b>3,224,587.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 74.5 хувь буюу 20,916.7 тэрбум төгрөгийг Төв болон орон нутгийн төрийн сан, 24.3 хувь буюу 6,820.8 тэрбум төгрөгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 1.2 хувь буюу 330.7 тэрбум төгрөгийг төсөвт байгууллага болон төсөл сангуудын өр төлбөр тус тус эзэлж байна.

### 7.1 Үнэт цаас, зээлийн өглөг

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өр, төлбөрт төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр, төлбөрийг нэгтгэн УСНББОУС-ын дагуу тайлагнадаг байна.

Нийт өр төлбөрийн 94.6 хувь буюу 26,576.0 тэрбум төгрөгийг үнэт цаас, зээлийн өглөг эзэлж байна.



Хүснэгт 19. Үнэт цаас, зээлийн өглөг

Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/-, Бууралт -/-	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
<b>Төв төрийн сангийн өр төлбөр дүн</b>	<b>16,718,464.8</b>	<b>20,627,157.7</b>	<b>3,908,692.9</b>	<b>77.6</b>
Дотоод бонд, векселийн дүн	4,164,232.8	3,250,985.2	-913,247.6	12.2
Гадаад үнэт цаас, бондын өглөг	5,570,905.4	8,219,985.4	2,649,080.0	30.9
Гадаад бондын өглөг	5,380,467.6	7,719,747.1	2,339,279.5	29.0
ОУВС /үнэт цаас/	190,437.8	500,238.3	309,800.5	1.9
Гадаад зээл /хөнгөлөлттэй/	6,983,326.6	9,156,187.1	2,172,860.5	34.5
<b>ТӨҮГ болон ОНӨҮГ-ын дүн</b>	<b>6,096,129.6</b>	<b>5,948,815.9</b>	<b>-147,313.7</b>	<b>22.4</b>
Үнэт цаасны өглөг	22,709.8	814,291.7	791,581.9	3.1
Зээлийн өглөг	6,025,317.5	5,058,030.7	-967,286.8	19.0
Бусад байгууллагын зээлийн өглөг	48,102.3	76,493.5	28,391.2	0.3
<b>Нийт дүн</b>	<b>22,814,594.4</b>	<b>26,575,973.6</b>	<b>3,761,379.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст Төв төрийн сангийн дотоод бондын өглөг 3,251.0 тэрбум, гадаад бонд 7,719.7 тэрбум, ОУВС-ийн хувь оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гаргасан үнэт цаас 500.2 тэрбум, гадаад зээл /хөнгөлөлттэй/ 9,156.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төв төрийн сангийн бонд болон зээлийн өглөг нийт 3,908.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### Төв төрийн сангийн үнэт цаас, зээлийн өглөг

Хүснэгт 20. Төв төрийн сангийн бонд, гадаад зээлийн өглөг

Үзүүлэлт	Дотоод бонд	Вексель	Гадаад бонд	Гадаад зээл /хөнгөлөлттэй/	Дүн
<b>Нэмэгдсэн дүн</b>	<b>3,376,640.3</b>		<b>3,445,064.0</b>	<b>2,362,381.8</b>	<b>9,184,086.1</b>
Тухайн онд шинээр гаргасан бонд, авсан зээл	3,376,640.3		3,445,064.0	2,229,591.9	9,051,296.2
Ханшийн алдагдал				132,789.9	132,789.9
<b>Хасагдсан дүн</b>	<b>5,403,527.5</b>	<b>307,230.0</b>	<b>1,123,892.1</b>	<b>189,521.3</b>	<b>7,024,170.9</b>
Үндсэн төлбөр	5,124,583.4	307,230.0	950,817.6	165,245.7	6,547,876.7
Ханшийн зөрүү	6,258.9		173,074.5	24,275.6	203,609.0
Буцаан худалдан авснаас хасагдсан	3,777.0				3,777.0
Хөнгөлөлт	268,908.2				268,908.2
<b>Хүүгийн төлбөр</b>	<b>562,502.0</b>	<b>45,999.2</b>	<b>408,536.0</b>	<b>113,635.4</b>	<b>1,130,672.6</b>

**Төв төрийн сангийн бонд, вексель, урт хугацаат зээл дараах байдлаар нэмэгджээ. Үүнд:**

- **Дотоод бондын өглөг:** Төсвийн дутагдлыг санхүүжүүлэхэд зориулж 3,376.6 тэрбум төгрөгийн богино, дунд хугацаат бонд гаргажээ.
- **Гадаад бондын өглөг:** Засгийн газрын 2017 оны 228 дугаар тогтоолоор өрийг дахин санхүүжүүлэх, өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх ачааллыг урт хугацаанд жигдлэх, өрийн багцын дундаж хугацааг уртасгах зорилгоор Олон улсын зах зээлд үнэт цаас арилжаалж 2018 онд эргэн төлөгдөх Засгийн газрын бондуудыг /Чингис, Дим сам/ дахин санхүүжүүлэхийг зөвшөөрч 800.0 сая ам.доллартай тэнцэх 5.625 хувийн хүүтэй 1,964.9 тэрбум төгрөгийн Гэрэгэ бонд гаргасан байна. Мөн Засгийн газрын 2017 оны 53 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкны дунд хугацааны евро бондыг /өрийн баталгаа/ солих, дахин санхүүжүүлэхийг зөвшөөрч 600.0 сая ам.доллартай тэнцэх 8.75 хувийн хүүтэй 1,480.2 тэрбум төгрөгийн Хуралдай бонд гаргажээ. Хуралдай бондыг 18.4 тэрбум төгрөгийг урамшуулалтай арилжаалж нийт 3,445.1 тэрбум төгрөгөөр гадаад бонд нэмэгдсэн байна.
- **Гадаад зээл:** Төслийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан авсан гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалт 2,229.6 тэрбум, ханшийн алдагдал 132.8 тэрбум нийт 2,362.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

**Төв төрийн сангийн бонд, вексель, урт хугацаат зээл дараах байдлаар хасагдсан байна. Үүнд:**

- **Дотоод бондын өглөг:** Төсвийн дутагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 3,333.3 тэрбум, өндөр хүүтэй бондыг хугацаанаас нь өмнө худалдан авахад зориулж 340.6 тэрбум, “Сайн” хөтөлбөрт зориулан гаргасан бондыг буцаан худалдан авахад 78.0 тэрбум, Хүний хөгжил сангийн бондын төлбөрт 372.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлсөн байна. Монгол Улсын Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн нэмэгдүүлэх зорилгоор гаргасан 1,000.0 тэрбум төгрөгийн дотоод бондыг Сангийн сайдын 2017 оны 104 дүгээр тушаалаар Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн баталгаатай суутган тооцоо хийж дотоод бонд нийт 5,124.6 тэрбум төгрөгөөр хасагдсан байна. Мөн бондын хөнгөлөлтийн төлбөрт 268.9 тэрбум, ханшийн зөрүүнээс 6.2 тэрбум төгрөг тус тус хасагдсан байна.
- **Векселийн өглөг:** Концессийн төлбөрийг векселиэр баталгаажуулсан “Ухаа худаг-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төлбөрт 119.5 тэрбум, Төмөртэйн ордоос Хандгайт өртөө хүртэлх төмөр замыг ачиж буулгах терминалын төлбөрт 183.6 тэрбум, “Жиансу Жунжиан Жианшин” компанид 4.1 тэрбум нийт 307.2 тэрбум төгрөг төлж, үлдэгдэлгүй болсон байна.
- **Гадаад бондын өглөг:** Чингис бонд 915.6 тэрбум, Дим сам бонд 35.2 тэрбум нийт 950.8 тэрбум төгрөгийн бондыг эргүүлэн худалдан авсан, ханшийн зөрүү 173.1 тэрбум төгрөгөөр тус тус хасагдсан байна.
- **Гадаад зээлийн өглөг:** Олон улсын байгууллагаас авсан урт хугацаат гадаад хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрт 165.2 тэрбум, ханшийн зөрүү 24.3 тэрбум нийт 189.5 тэрбум төгрөгөөр гадаад зээлийн өр хасагдсан байна.

**7.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн зээлийн өглөг**

Зээлийн өглөг оны эхэнд 6,025.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 5,058.0 тэрбум төгрөг болж 967.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зээлийн үлдэгдэлд 95.8 хувь буюу 4,848.2 тэрбум төгрөгийг дараах байгууллагуудын зээл эзэлж байна. Үүнд: Монгол Улсын Хөгжлийн банк 1,812.3 тэрбум, Төрийн банк 1,999.6 тэрбум, “МИАТ” ТӨХК 189.4 тэрбум, “Монголын төмөр зам” ТӨХК 86.6 тэрбум, “ТОСК” ТӨХК 140.9 тэрбум, “Хадгаламж даатгалын корпораци” ХК 190.8 тэрбум, “Эрдэнэс Тавантолгой” ХК 153.1 тэрбум, “Эрдэнэс Монгол” ХХК 83.5 тэрбум, ЭХЯ-ны харьяа Цахилгаан дамжуулах болон түгээх станцууд 192.0 тэрбум төгрөгийн өглөгүүд тус тус байна.

**7.3 Дансны өглөг**

Дансны өглөг 89.8 тэрбум төгрөгөөр буурч 1,043.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 57.8 хувь, төрийн сан 25.9 хувь, төсвийн байгууллага 15.4 хувь, төсөл сан 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлөх нийт өглөг 59.7 тэрбум төгрөг байгаагийн “МИАТ” ТӨХК 17.5 тэрбум, ИНЕГ 2.4 тэрбум, “Эрдэнэс Тавантолгой” ХК 14.4 тэрбум, “Диспетчерийн үндэсний төв” ХХК 0.9 тэрбум төгрөг, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 1.2 тэрбум, “Шивээ овоо” ХК 2.9 тэрбум төгрөгийн дансны өглөг тус тус байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Төрийн өмчит хуулийн этгээдийн татвар, НДШ-ийн өглөг өмнөх оноос 14.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 59.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба татвар, шимтгэлийг хуулийн хугацаанд төлөөгүй;
- Төсвийн захирагчдын 2013-2015 онд татан төвлөрүүлсэн харилцах дансны үлдэгдэл 7.7 тэрбум төгрөгийн өглөгийг шийдвэрлээгүй;
- Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 196.9 тэрбум төгрөгийн зээлийн өглөг ЗТХЯ, Эрчим хүчний хөгжлийн төвийн санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

## Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 349.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 313.1 тэрбум төгрөг болж, 36.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 21. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, Бууралт -/	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөрийн дүн</i>	215,995.3	152,110.5	-63,884.8	48.6
Богино хугацаат зээлийн өглөг	7,832.3	10,775.1	2,942.8	3.4
Богино хугацаат өглөг	140,870.6	89,654.2	-51,216.4	28.6
Урьдчилж орсон орлого	67,292.4	51,681.2	-15,611.2	16.5
<i>Урт хугацаат зээл</i>	133,901.6	160,962.3	27,060.7	51.4
<b>Нийт дүн</b>	<b>349,896.9</b>	<b>313,072.8</b>	<b>-36,824.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын дамжуулан зээлийн өглөгийн талаар:

Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээс орон нутагт дамжуулан зээлдүүлсэн зээлийн өглөг Азийн хөгжлийн банкны 36, Дэлхийн банкны 10, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 2, Франц улсын 1, БНСУ-ын 2, Испани улсын 1, нийт 52 санхүүжүүлэгч байгууллагын 305.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байна.

Дээрх дамжуулан зээлийг аймаг, орон нутгийн гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, төвлөрсөн системд холбох, худаг гаргах зэрэгт зориулан олгосон байна.

### Аудитын илрүүлэлт:

Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 1994-2014 онд байгуулсан орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлийн 37 зээлийн гэрээний 65.5 тэрбум төгрөгийн зээл, 27.5 тэрбум төгрөгийн хүү хугацаандаа хуваарийн дагуу төлөгдөөгүй байна.

## Найм. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцооны эхний үлдэгдэл 6,316.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 17,453.7 тэрбум төгрөг болж, 11,137.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 22. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, Бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,155,062.1	4,027,615.2	-127,446.9
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,860,724.5	3,067,962.6	207,238.1
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	175.1	20,369.9	20,194.8
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	38,355.9	11,234,355.9	11,196,000.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	33,784.2	37,572.4	3,788.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,352,268.3	2,523,572.8	171,304.5
Хуримтлагдсан үр дүн	-5,032,738.6	-5,342,622.7	-309,884.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,892,819.3	1,869,444.9	-23,374.4
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	15,853.1	16,109.2	256.1
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		-627.5	-627.5
<b>Дүн</b>	<b>6,316,303.9</b>	<b>17,453,752.6</b>	<b>11,137,448.7</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 8.1 Төрийн өмчийн хувь оролцоо

ТЕЗ-дын Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,222.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 12,834.0 тэрбум төгрөг болж, 10,611.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

УУХҮЯ-ны Засгийн газрын хувь оролцооны өсөлт нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг санхүүгийн тайланд тусгасан болон дүрмийн санг нэмэгдүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг дараах тогтоолыг үндэслэн данс бүртгэлд тусгасан байна. Үүнд:

- Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт 15.0 тэрбум хувьцааны 80.0 хувь буюу 12.0 тэрбум ширхэг хувьцааг гаргасан хувьцаагаар, 20.0 хувь буюу 3.0 тэрбум ширхэг хувьцааг зарласан хувьцаагаар компанийн дүрэмд тусгаж бүртгэхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай” гэсэн заалт;
- Дээрх тогтоолын 8.1-т “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаанаас хишиг хувь хүртсэн болон Засгийн газарт нэрлэсэн үнээр хувьцаагаа худалдсан иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанд нэмэгдүүлэн бүртгэж, шинээр хувьцаа эзэмших болон хувьцаагаа буцаан худалдан авах хүсэлт гаргаж төлбөрөө шилжүүлсэн иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанаас шилжүүлэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг цэгцлэх ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хэрэгжүүлэх” гэж заасны дагуу 12.0 тэрбум ширхэг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг 11,196.0 тэрбум төгрөгөөр 2017 онд санхүүгийн тайланд тусгасан байна.
- Тогтоолын 7 дугаар зүйлд “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл бүхий ордуудыг үнэлж, компаниудын үнэлгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 24. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа

Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	Нэгжийн үнэ	Хувьцааны үнийн дүн /сая төгрөг/
"Эрдэнэс Тавантолгой" ХХК /1072/	9,780,711,099	933	9,125,403.4
Монгол Улсын хуулийн этгээд /486/	7,065,038	933	6,591.7
Монгол Улсын иргэнд /2,511,332/	2,212,223,863	933	2,064,004.9
<b>Дүн</b>	<b>12,000,000,000</b>		<b>11,196,000.0</b>

Мөн эздийн өмч данс дараах байгууллагуудын өмчийн өөрчлөлт 6.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК-ийн хувь оролцооны нэмэгдэл 2.7 тэрбум төгрөг;
- Замын-Үүдийн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын дүрмийн сангийн өсөлт 3.5 тэрбум төгрөг,
- “Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-ийн дүрмийн сангийн өсөлт 0.06 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Хүснэгт 25. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эздийн өмч

Байгууллагын нэр	Хөрөнгө оруулалтын дүн /сая төгрөг/
"Эрдэнэс монгол" ХХК	2,780.8
Замын-Үүдийн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ	3,593.0
“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ	61.6
<b>Дүн</b>	<b>6,435.4</b>

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 129 төрийн өмчит хуулийн этгээдээс 128 нь тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж, ТӨБЗГ-ын 2017 оны 410 дугаар тогтоолоор “Оргил” рашаан сувиллыг хувьчилж өмчлөх эрхийг шилжүүлсэн байна.

Эдгээрээс 88 байгууллага буюу 68.8 хувь нь 687.6 тэрбум төгрөгийн ашигтай, 31.2 хувь буюу 40 байгууллага нь 47.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Санхүүгийн тайлан дахь эздийн өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн сангийн дүнгээс “Удирдлагын академи” УТҮГ 0.3 тэрбум, СУИС 0.7 тэрбум, “Харгуй” ТӨХК 0.4 тэрбум, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ТӨҮГ 0.2 тэрбум, “Биокомбинат” ТӨҮГ 0.9 тэрбум төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн;
- Улсын ТЕЗ-дын харьяа байгууллагууд 47.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тухайлбал: “ТОСК” ТӨҮГ 20.4 тэрбум, “Амгалан дулааны станц” ХХК 6.0 тэрбум, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 4.2 тэрбум, “Радио телевизийн сүлжээ” УТҮГ 3.0 тэрбум, “Дарханы ДЦС” ТӨХК 2.4 тэрбум, “Алтай-Улиастай эрчим хүчний систем” ТӨХК 2.2 тэрбум, “Эгийн голын усан станц” ХХК 2.1 тэрбум, “Эрдэс Оюу толгой” ХХК 1.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

## 8.2 Орон нутгийн өмчийн хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,093.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,619.7 тэрбум төгрөг болж, 526.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн өмчит 418 хуулийн этгээдээс 403 байгууллага 2017 онд үйл ажиллагаа явуулж, 15 байгууллага татан буугдсан байна. Үүнээс 182 байгууллага буюу 45.2 хувь нь 7.8 тэрбум төгрөгийн ашигтай, 221 байгууллага буюу 54.8 хувь нь 62.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 62.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тухайлбал: Нийслэлийн харьяа Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 3.2 тэрбум, Ус сувгийн удирдах газар 10.2 тэрбум, Геодези, усны барилга байгууламжийн газар 1.6 тэрбум, Зорчигч тээврийн нэгтгэл 2.6 тэрбум, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар 0.4 тэрбум, Тээвэрлэлт, үйлчилгээний төв 0.5 тэрбум, Багахангай дүүргийн Мах боловсруулах үйлдвэр 21.2 тэрбум, Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨҮГ 0.7 тэрбум, Өмнөговь аймгийн “Шугшаа уул” ОНӨҮГ 0.4 тэрбум, Дулаан хангамжийн газар 0.5 тэрбум, Баянхонгор аймгийн “Чандмань” ХХК 4.7 тэрбум, Дархан-Уул аймгийн “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨҮГ 1.4 тэрбум, “Дархан ус суваг” 0.6 тэрбум, Увс аймгийн “Дулааны станцын ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨҮГ 1.2 тэрбум, Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ энерго” ОНӨҮГ 0.6 тэрбум, Ховд аймгийн “Үенч-Эрчим хүч” ОНӨҮГ 0.6 тэрбум, Орхон аймгийн “Эрдэнэт-Ус” ДТС ОНӨХК 0.7 тэрбум, Сүхбаатар аймгийн “Дөрвөлж” ОНӨҮГ 1.1 тэрбум, Говь-Сүмбэр аймгийн “Ус-Ду” ОНӨҮГ 0.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

## Ес. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн

### 9.1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 13,385.6 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 11,953.9 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 5.1 тэрбум төгрөгийн зөрчилд 278 төлбөрийн акт тогтоож, 792.7 тэрбум төгрөгийн зөрчилд 381 албан шаардлага хүргүүлж, 0.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 41 санал хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах 633.8 тэрбум төгрөгийн 2186 зөвлөмж өглөө.

Тайлант хугацаанд 32 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, 28 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, 4 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд: БСШУСС, УУХҮС, ХНХС, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан байна.

## 9.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 287.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 138.6 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 3.4 тэрбум төгрөгийн зөрчилд 1024 акт тогтоож, 59.7 тэрбум төгрөгийн зөрчилд 913 албан шаардлага хүргүүлж, 1.3 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 37 санал хүргүүлж, 84.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 3511 зөвлөмж тус тус өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 20 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгчээ.

## 9.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Улсын ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт зөрчлийн 90.0 хувь буюу 12,047.4 тэрбум төгрөг нь төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчил байна.

Илэрсэн нийт зөрчлөөс 11,437.8 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.4 тэрбум төгрөгийн зөрчилд 22 төлбөрийн акт тогтоож, 284.4 тэрбум төгрөгийн зөрчилд 63 албан шаардлага хүргүүлж, 324.8 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 375 зөвлөмж хүргүүлжээ.

Нийт 128 төрийн өмчит хуулийн этгээдээс 109 байгууллага аудитад хамрагдаж, 93 “Зөрчилгүй”, 13 “Хязгаарлалттай”, 2 “Сөрөг”, 1 “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 25. “Хязгаарлалттай”, “Сөрөг” болон “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өгсөн байгууллагууд

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт:

1.Булган Хангал Спорт бэлтгэлийн төв

“Сөрөг” санал дүгнэлт:

1.Биокомбинат ТӨҮГ

2.Дорнод их сургууль

“Хязгаарлалттай” санал дүгнэлт:

1.Багабаян-энхийн төлөө цогцолбор ТӨААТҮГ

2.Бөртэ ТӨААТҮГ

3.Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл

4.Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ

5.Монгол Улсын Их сургууль

6.Ховд их сургууль

7.Булган АЗЗА ТӨХК

8.Монголын төмөр зам ТӨХК

9.Мон-Атом" ХХК

10.“Шивээ овоо” ТӨХК

11.“Эрдэнэс Тавантолгой” ХК

12.“Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын төв” ТӨҮГ

13. "Монгол тамга" ТӨААТҮГ

Эдгээр байгууллагуудад хийсэн аудитаар хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгө нь биетээр оршин байхгүй, тооллого тооцоог хугацаанд нь хийгээгүй, он дамжсан, хугацаа хэтэрсэн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, орлогыг дутуу тусгасан, татвар, НДШ-ийг дутуу төвлөрүүлсэн зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

## 9.4 Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газар 2017 оны байдлаар хандивлагч 5 орон, олон улсын 6 санхүүгийн байгууллага болон гадаадын 7 орны санхүүжилтээр 90 төслийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 26. Төслийн санхүүжилтийн эх үүсвэр

Төслийн санхүүжилтийн хэлбэр	Төслийн тоо	Нийт гэрээний дүн /сая нэгж/							
		төгрөг	доллар	евро	иен	Зээлжих тусгай эрх	Швейцарь франк	крон	юань
Зээлийн хөрөнгөөр	54	-	1,047.3	57.6	90,335.0	308.6	-		
Буцалтгүй тусламжаар	36	8,996.2	100.9	18.8	-	-	10.2	29.7	146.4
<b>ДҮН</b>	<b>90</b>	<b>8,996.2</b>	<b>1,148.2</b>	<b>76.4</b>	<b>90,335.0</b>	<b>308.6</b>	<b>10.2</b>	<b>29.7</b>	<b>146.4</b>

Зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжихээр гэрээ байгуулагдсан 109 төсөл, хөтөлбөр бүртгэлтэй байгаагаас зээлийн хөрөнгөөр 54, буцалтгүй тусламжаар 36, нийт 90 төсөл хэрэгжиж, 19 төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдаагүй, шинээр эхлэх төслүүд байна.

Тайлант онд Үндэсний аудитын газар 3, хараат бус аудитын хуулийн этгээд 29, нийт 32 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалттай” 2, “Зөрчилгүй” 30 санал дүгнэлтийг өгсөн байна. Үүнээс ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй “Сүрьеэгийн өвчлөлийг бууруулах нь”, “ДОХ-ын бага тархалтыг тогтоон барих нь” төслийн нэгжүүдийн санхүүгийн тайланд авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, зөрүүтэй бүртгэсэн, тооцооны буцаалтыг орлогоор хүлээн зөвшөөрсөн, зарим зардлыг гүйлгэн зарцуулсан үндэслэлээр “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгчээ.

Мөн Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-д заасан жишиг цалин, ажлын хөлсийг тогтоох үнэлгээний шалгуур, хөлсөөр ажиллах гэрээ, хүүгийн орлогын зарцуулалтын талаарх заалтууд нь холбогдох хуулиудын заалтуудтай зөрчилдөж байна.

Улсын ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт зөрчлийн 0.2 хувь буюу 27.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил нь төслийн нэгжийн санхүүгийн тайланд илэрсэн байна.

Илэрсэн нийт алдаа, зөрчлөөс 17.5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 3.1 тэрбум төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6.6 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 48 зөвлөмжийг өгсөн байна. Төсөл, хөтөлбөрийн нэгжүүдээс 27 нь аудитад хамрагдаагүй байна.

### 9.5 Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Улсын ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн 2.5 хувь буюу 333.8 тэрбум төгрөг нь Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд илэрсэн байна.

Илэрсэн нийт алдаа, зөрчлөөс 53.0 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 2.1 тэрбум төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 249.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 24 албан шаардлага хүргүүлж, 29.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 161 зөвлөмж, 12 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлсэн байна.

Засгийн газрын 12 тусгай санд төрийн аудитын байгууллага, 2 тусгай санд хараат бус аудитын хуулийн этгээд, 8 тусгай санг түүврээр санхүүгийн тайлангийн аудитад хамруулснаас 10 тусгай сан “Зөрчилгүй”, Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан “Хязгаарлалттай”, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан “Сөрөг” санал, дүгнэлттэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

Боловсролын зээлийн сан:

- 21.6 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан суралцагчдын төлбөрийг 4 жилээр санхүүжүүлж, голч оноог харгалзан сургалтын төлбөрөөс чөлөөлөх нарийвчилсан журамгүйгээр 4.8 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийг олгосон;
- 2017 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан 51 төгсөгчийн 3.3 тэрбум төгрөгийн сургалтын зээлийг Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн БСШУСС-ын 2017 оны А/88 дугаар тушаалаар чөлөөлсөн;

Шинжлэх ухаан технологийн сан:

- 1.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн, 0.4 тэрбум төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

- 0.8 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

- 7.0 тэрбум төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд 1.2 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг тусгаагүй, зээлийн төлөх хугацаа нь дууссан, зээлээ төлөөгүй 2.4 тэрбум төгрөгийн 22 зээлдэгчийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй;
- 2017 онд төлөх 1.4 тэрбум төгрөгийн үндсэн зээл, 0.3 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр тус тус төлөгдөөгүй байна.

## **Арав. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга**

Аудитаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 3.5 тэрбум төгрөгийн өр төлбөрийг улсын төсвийн орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, 7.2 тэрбум төгрөгөөр урт хугацаат хөрөнгө оруулалтыг дутуу тусгасан, 62.6 тэрбум төгрөгийн авлага, өглөгийн цэвэрлэх бичилтийг дутуу хийсэн алдааг залруулсан болно.

ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар цэвэрлэх бичилт дутуу хийгдсэн, орлого, зардлыг зөрүүтэй тайлагнасан, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой дансны бичилтийг буруу хийсэн зэргээс нийт улсын 26 ТЕЗ-дын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 11,943.1 тэрбум, орон нутгийн 22 ТЕЗ-дын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 262.8 тэрбум төгрөгийн алдааг залруулжээ.

## **Арван нэг. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт**

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Ерөнхий сайдад 5, Сангийн сайдад 5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2 зөвлөмжийг тус тус өгснөөс нийт 12 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд 52.6 хувийн биелэлттэй байна.

- Ерөнхий сайдад өгсөн 5 зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдүүдийн харьяалагдах ТЕЗ-дыг тодорхой болгох, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг баталгаажуулах, хувьцааг бүртгэн хувь нийлүүлсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгах талаарх 2 зөвлөмжийг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна;
- Сангийн сайдад өгсөн 5 зөвлөмжөөс Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр орон нутгийн банкинд нээсэн дансдыг хаах зөвлөмж хэрэгжиж, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэх зөвлөмжийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа, 3 зөвлөмж нь хэрэгжээгүй байна;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт өгсөн 2 зөвлөмжөөс алдагдалтай ажиллаж байгаа, санхүүгийн зохистой харьцаа алдагдсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах, ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчит хуулийн этгээдийг тодорхой болгож, санхүүгийн нэгтгэсэн тайланд хамруулах талаар өгсөн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.



## **Арван хоёр. Дотоод аудит**

ТЕЗ-д Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана” гэж заасны дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь дотоод аудитын албадыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангадаг байна.

ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй, давтагдаж байгаа нь төсөв захирагчдын дэргэдэх дотоод аудитын үйл ажиллагаа, үр дүн болон удирдлагын дотоод хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

Иймд төсвийн захирагчид дотоод аудитын нэгжээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, дотоод аудитын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

## **Арван гурав. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж**

Төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэлийн програм хангамжуудыг шинэчлэгдсэн стандартуудтай цаг тухайд нь нийцүүлэн сайжруулалт хийхгүй байна.

## **Арван дөрөв. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ-Д:

- Байгалийн баялгийн нөөцийг тогтоож, үнэлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн эзэмшлийн хөрөнгийн дүнг үнэн зөв бүртгэж, тайлагнах;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагааг дээшлүүлэх, менежментийн хариуцлагыг сайжруулахад чиглэгдсэн зорилтот түвшинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төсвийн ерөнхийлөн захирагчидтай зөвшилцөн батлах, хэрэгжилтийг хянаж, үнэлэх талаар шийдвэр гаргах;
- Тусгай сангуудын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, сангаас олгосон санхүүжилт болон зээлийг шалгуурт нийцүүлэн олгож байх, зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагааг чанаржуулж, салбарын онцлогт тохирсон бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох.

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР-Т:

- Аккруэл суурьт УСНББОУС-ыг үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж нь УСНББОУС-д нийцсэн эсэхэд судалгаа, дүгнэлт хийж, бүртгэлийн стандартуудтай цаг тухайд нь нийцүүлэх арга хэмжээ авах;
- Сангийн яамны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн “Э-тайлан” програмд төсвийн захирагч хооронд хийгдсэн ажил гүйлгээ, үүссэн авлага, өглөгийн давхардлыг цэвэрлэх бичилтийн үйлдлийг тохируулах хөгжүүлэлт хийх;
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-ыг холбогдох хууль, эрх зүйн актуудтай нийцүүлэх.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМ-ОСОР-Т:

- Хөрөнгө оруулалт, концесс, гадаад зээл тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, тайлагналд тавих хяналтыг сайжруулах;
- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн улсын төсөвт төвлөрүүлэх орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай<sup>1</sup>

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан”-г нэгдүгээр хавсралтаар, санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад тус тус зөвлөсүгэй.


4. Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт, тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын  
 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн  
 А/136 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН  
 АУДИТААР ТОГТООСОН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Төлбөр хариуцагч байгууллага	Албан шаардлагын огноо, дугаар	Тогтоосон ажилтан	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /гэрбум төгрөгөөр/
1	Сангийн яамны Төрийн сангийн газар	2018.06.08 01/217	Ахлах аудитор Л.Хонгорзул Ахлах аудитор Ц.Хосжаргал	Төсвийн захирагчдын харилцах дансны үлдэгдлээс 2013-2015 онд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг шийдвэрлээгүй	7.7
				Гадаад дамжуулан зээлээс зээлдүүлсэн үндсэн болон хүүгийн төлбөрийн авлага, 1991-1996 онд аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон зээлийн найдваргүй болох эрсдэлтэй авлага, банк, хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой авлагын үлдэгдлийг шийдвэрлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй	762.9
				Төв төрийн санд бүртгэлтэй, олон жилийн насжилттай, банк, хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой авлагын үлдэгдлийг шийдвэрлээгүй	158.4
<b>НИЙТ ДҮН</b>					<b>929.0</b>

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР